# УЛААНБААТАР ХОТЫН БАНК
# ULAANBAATAR CITY BANK



Жилийн Тайлан 2004 Annual Report

# АГУУЛГА
# Contents


| | | |
|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот<br>*Ulaanbaatar City* | 2 |
| 2. | Хувь нийлүүлэгчдийн хурлын дарга, Нийслэлийн засаг дарга бөгөөд хотын захирагч М.Энхболдын илгээлт<br>*Message from the Chairman of the Shareholders Meeting* | 3 |
| 3. | Гүйцэтгэх захирлын мэндчилгээ<br>*Message from the Executive Director* | 5 |
| 4. | Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тойм<br>*Outlook on socio-economic environment* | 8 |
| 5. | Банк санхүүгийн систем<br>*Outlook on banking sector* | 10 |
| 6. | Улаанбаатар хотын банкны үүсэл, хөгжил<br>*Corporate outline* | 12 |
| 7. | Бүтэц зохион байгуулалт<br>*Organization* | 13 |
| 8. | Шагнал, өргөмжлөл - 2004<br>*Awards and prizes - 2004* | 14 |
| 9. | Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд<br>*Main financial indicators* | 15 |
| 10. | Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ<br>*New Products and Services* | 18 |
| | 10.1 Банкны бүртгэлийн шинэ программ нэвтрүүллээ.<br>*Modern accounting software* | 18 |
| | 10.2 Даатгагдсан хадгаламж, даатгагдсан ирээдүй.<br>*"Insured deposits -Insured Future"* | 19 |
| 11. | Банкны хаяг, байршил<br>*Head office and branches* | 20 |
| 12. | Гадаадын банкууд дахь харилцах данс<br>*Correspondent banks* | 21 |
| 13. | Хөндлөнгийн хяналтын тайлан<br>*Auditor's Report* | 22-30 |

# УЛААНБААТАР ХОТ
# Ulaanbaatar City

Улаанбаатар хот нь 1639 онд байгуулагдсан 365 жилийн түүхтэй Монгол улсын нийслэл хот юм.

Нийслэл хотын нэр олон удаа солигдож байсан ба Өргөө, Номын хүрээ, Их хүрээ, Да хүрээ, Нийслэл хүрээ гэх зэргээр нэрлэгдэж байсан. Ардын хувьсгал ялсны дараа 1924 онд Улаанбаатар хэмээн нэрлэгдсэн. Түүнээс хойш 81 жилийн турш Улаанбаатар хот хэмээн нэрлэгдэж иржээ.

Улаанбаатар хот нь Ази тивийн төв хэсэгт буюу Богд хан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх гэсэн дөрвөн уулын дунд Туул голын хөвөөнд 470 мянган га газрыг эзлэн оршдог ба далайн түвшнээс 1351 гаруй метрийн өндөрт оршдог байна.

Улаанбаатар хотод албан тоогоор 870 мянган хүн, албан бус тоогоор 1 сая гаруй хүн амьдардаг ба Монгол улсын нийт хүн амын 40 орчим хувь нь нийслэл хотод амьдарч байна гэсэн үг. Улаанбаатар хот нь 9 дүүрэг, 117 хороодоос бүтсэн засаг захиргааны нэгжтэй.

Монгол улсын нэг жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 60 орчим хувийг, төсвийн орлогын хоёрны нэгийг Улаанбаатар хот дангаараа бүрдүүлдэг. Тэр ч утгаараа Улаанбаатар хот нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зүрх нь болсон газар юм.

The Ulaanbaatar City, the capital city of Mongolia, was established in 1639. Throughout its history of 365 years, its name has been changed several times: it has been called as Urghuu, Nomyn Khuree, Ikh Khuree, Da Khuree and Niislel Khuree. After the victory of the people's revolution in 1924, it was named as Ulaanbaatar, the name it kept for 81 years until the present.

The Ulaanbaatar City is located at the heart of Asia, surrounded by four mountains such as Bogd Khaan, Songinokhairkhan, Chingeltei and Bayanzurkh, lying at the Tuul River valley. It has a territory of 470 thousand hectares, and is situated at more than 1351 meters above the sea level.

According to the official data, the city has a population of 870 thousand people, whereas estimates suggest that unofficially its population reaches more than one million. More than 40 percent of its residents live in urban area. The Ulaanbaatar City consists of 9 districts and I 17 khoroos, an administrative unit of a district.

The Ulaanbaatar City alone accounts for nearly 60 percent of Mongolia's Gross Domestic Product as well as for the half of the state budget revenue. In this sense, Ulaanbaatar is regarded as the heart of the country's socio-economic development.



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД ХОТЫН ЗАХИРАГЧ М. ЭНХБОЛДЫН ИЛГЭЭЛТ

## Message from Mr.M.Enkhbold , Chairman of Shareholders Meeting and Mayor of Ulaanbaatar City



Та бүхэндээ Улаанбаатар хотын банкнаас 2004 онд хийсэн ажилололт, амжилтаа тайлагнаж байгаадаа баяртай байна. Өнгөрсөн онд тус банкны хувь нийлүүлэгч болон нийт ажиллагсдын хувьд ажилдаа өөрчлөлт шинэчлэлт хийсэн онцгой жил болж өнгөрлөө.

2004 онд банк бүтэц зохион байгуулалтаа оновчтой болгож, харилцагчдын өсөн нэмэгдэж байгаа эрэлт, хэрэгцээнд нийцсэн чанартай, шуурхай үйлчилгээ үзүүлж, санхүүгийн зах зээлд эзлэх байр суурьа нэмэгдүүлж чадлаа.

Улаанбаатар хотын банкны нийт активын хэмжээ өнгөрсөн онд 2.5 дахин өссөн нь иргэд, харилцагчдын манай банкинд итгэх итгэл өсөн нэмэгдэж, үйл ажиллагаа сайжирч буйг харуулж байна.

I am pleased that the Ulaanbaatar City Bank is presenting its Annual Report 2004 to you, outlining their activities and achievements. Last year has been a remarkable one, full of reforms and innovative initiatives for the bank's shareholders and staff.

In reporting year, the bank has undertaken a comprehensive reorganization, and raised the quality of its products and services, thus meeting the increased needs and expectations of customers and strengthened its position in the banking sector.

The fact that the bank's total assets have increased 2.5 times in 2004, demonstrates the growing customers confidence and improvement of the bank's overall activities.

Банкны 2004 онд хийсэн ажлыг үнэлж Монгол Улсын засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас Монгол Улсын шилдэг банкаар шалгарууллаа. Мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр ``Нийслэлийн шилдэг байгууллага``өргөмжлөл, TV9 телевизээс "Оны шилдэг аж ахуйн нэгж", мөн банкны гүйцэтгэх захирал Д.Бадраа ``ENTERPRENEUR 2004`` шалгаруулалтаас ``Банк санхүүгийн системийн шилдэг менежер``, 2004 оны Нийслэлийн шилдэг залуу хүндэт өргөмжлөлөөр шагнагдлаа. Энэ бүх шагнал урамшуулал нь банкны харилцагч иргэд, хамтран ажилладаг гадаад, дотоодын байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүн юм.

Тус банк нийслэлийнхээ хөгжил цэцэглэлтэнд идэвхитэй оролцож байгаа бөгөөд цаашид ч хотын нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Та бүхэнд ажил хөдөлмөрийн өндөр амжилт, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**М. Энхболд**
*Хувь нийлүүлэгчдийн хурлын дарга,*
*Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч*

In recognition of its achievements, the Government of Mongolia and the Mongolian National Chamber of Commerce and Industry ranked the bank among the top ten banks of the country in 2004. With the decision of the Citizens Representatives Assembly of the Capital City, the bank was awarded as "The best Business Enterprise of the Capital city in 2004", and by the TV9 Television the bank's "Insured Deposit Service" was selected as the best banking product that enjoys customer satisfaction. Moreover, the bank's Executive Director, Mr. D. Badraa has won the award of "The Best Manager of the Banking System" in the "ENTREPRENEUR-2004" contest, and was nominated as "The Best Young Fellow of the Capital City" in 2004. All these awards and prizes are the result of fruitful cooperation of the bank's staff members, customers and domestic and international partner organizations.

I should also note that the Ulaanbaatar City Bank has been actively involved in fostering the economic prosperity of the Capital City, and I am confident that it will continue to contribute to the socio-economic development of the City.

Taking this opportunity, I would like to extend my best wishes for success in your endeavors and happiness.

Sincerely yours,

**M. Enkhbold**
*Chairman of the Shareholder Meeting and*
*Mayor of Ulaanbaatar City*

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ
## Message from the Executive Director



Өнгөрөгч 2004 он Улаанбаатар хотын банкны хувьд санхүү, менежментийг хүчирхэг болгох, үйл ажиллагаагаа харилцагч руу улам ойртуулах зорилгоор банкны дотоод бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, бүх төрлийн эрсдэлийн удирдлагыг оновчтой болгох, төлбөрийн чадвараа бэхжүүлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж байгаа эрэлт, хэрэгцээнд нийцсэн чанартай, шуурхай үйлчилгээ үзүүлэх талаар тодорхой арга хэмжээ авсанаар санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж чадлаа.

Банкны менежмент, маркетингийн үйл ажиллагаанд илүү ач холбогдол өгч, хэд хэдэн шинэлэг үйлчилгээ бий болгож, даатгагдсан хадгаламжийн шинэ үйлчилгээг банк санхүүгийн зах зээлд анх удаа нэвтрүүлсэн нь олны талархлыг хүлээлээ. Харилцагчиддаа хүргэж буй олон талт үйлчилгээг чанаржуулах, илүү хүртээмжтэй, ойлгомжтой болгох үүднээс харилцагчийн газрыг шинээр байгуулан, шууд маркетингийн аргыг ашиглаж байгаа нь үр дүнгээ өгч байна.

In 2004, in order to improve the bank`s management, to strengthen its financial standing, and to bring its products and services closer to customers - Ulaanbaatar City Bank has successfully conducted a range of activities. By utilizing an efficient risk management system, restructuring the corporate organization, and taking necessary steps to meet the nowadays increased and sophisticated needs of our customers - we have managed to further extend and strengthen our position within the banking sector.

Particular attention has been given to the bank`s management and marketing. A number of innovative services including insured deposits have been introduced, and were highly appreciated by our customers. With a view to raising the quality of our services and making them more accessible and comprehensible, we have set up a new customers unit and applied direct marketing techniques that are bringing their results.

Манай банкны гадаадын болон олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагаа өргөжлөө.

Улаанбаатар хотын банкны нийт активын хэмжээ 2004 онд өмнөх оныхоос 2.5 дахин буюу 20.7 тэрбум төгрөгөөр, татан төвлөрүүлсэн хөрөнгө 15.8 тэрбум төгрөгөөр өссөн нь манай банкинд харилцагчдын итгэх итгэл нэмэгдэж байгааг харуулж байна.

2005 онд бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүдийг нэвтрүүлж, байгууллага, иргэдийн төлбөр тооцоог хурдасгах, хялбаршуулах, өөрийн нэрийн карт гаргах, нийслэлийн хөгжилд дорвитой хувь нэмрээ оруулах зорилготой байна. Өнгөрсөн онд олсон амжилтаа улам бүр бататгаж, үйл ажиллагаагаа өргөжүүлж, үр ашгаа мэдэгдэхүйц нэмэгдүүлэхийн төлөө бүх нөөц боломжоо ашиглан ажиллах болно.

Манай банкны үйл ажиллагааг дэмжин бидэнд итгэл хүлээлгэн хамтран ажилладаг харилцагч, үйлчлүүлэгч бүх иргэд, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэр аж ахуйн газруудад банкныхаа хувь нийлүүлэгч, нийт ажиллагсдынхаа нэрийн өмнөөс талархал илэрхийлж, ажлын амжилт, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**Д.Бадраа**
*Гүйцэтгэх захирал*

Our bank has also expanded its cooperation with domestic and international banking and financial institutions.

Between 2003 - 2004, the bank's total assets increased by 2.5 or by 20.7 billion MNT, accumulated assets rose by 15.8 billion MNT, thus reflecting the increased customers confidence in the bank.

For the year 2005, the bank sets a range of tasks such as introducing non-cash payment settlement facilities, making customer payment settlements faster and simpler, issuing own banking cards and giving a substantial contribution to the overall development of the Capital City. We will do our best to consolidate our last years achievements, further expand our activities and raise our operational efficiency.

On behalf of all the members of staff and shareholders of the bank, I would like to express our sincere gratitude to all of our esteemed clients, domestic and international partner institutions, government and non-government organizations and business enterprises for their dedicated support and confidence extended to us, and wish you a success in your endeavors and happiness.

Sincerely yours,

**D. Badraa**
*Executive Director*

# ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ
## Board of Directors



**Б.Батхүү**
*Дэд захирал*
**B.Batkhuu**
*Deputy Director*



**Д.Мөнхбаатар**
*Зөвлөх*
**D.Munkhbaatar**
*Advisor*



**Л.Мөнхзул**
*Үйл ажиллагааны газрын захирал*
**L.Munkhzul**
*Operational Department Director*



**Ж.Эрдэнэбилэг**
*Дотоод аудитын газрын захирал*
**J.Erdenebileg**
*Internal Audit Department Director*



**Д.Сүхбаатар**
*Мэдээлэл технологийн хэлтсийн захирал*
**D.Sukhbaatar**
*Information Technology Division Director*



**В.Норовсүрэн**
*Эрсдлийн удирдлагын газрын захирал*
**V.Norovsuren**
*Risk Management Department Director*



**О.Банзрагч**
*Харилцагчийн газрын захирал*
**O.Banzragch**
*Business Banking Department Director*



**А.Мандах**
*Тусгай активын газрын захирал*
**A.Mandakh**
*Special Assets Department Director*

# МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ - 2004
## Outlook on socio-economic environment

Монгол улсын нийгэм эдийн засгийн байдалд сүүлийн хэдэн жил ахиц гарч байна. 2004 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 692.8 тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 717.3 тэрбум төгрөг болж, нийт тэнцэл 24.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн урсгал орлого 685.9 тэрбум төгрөг, урсгал зардал 525.8 тэрбум төгрөг болж, урсгал тэнцэл 160.1 тэрбум төгрөгийн ашигтай байна.

ДНБ-ний бодит өсөлт 2001 онд 1.1 хувь, 2002 онд 3.7 хувь, 2003 онд 5.6 хувь байсан бол 2004 онд урьдчилсан тооцооллоор 10.6 хувь өсөлттэй байхаар гарчээ. Улс орны эдийн засгийн гол үзүүлэлт болсон ДНБ сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа нь эдийн засаг макро түвшиндөө сайжирч байгааг илэрхийлэх ба энэ нь банкны болон харилцагчдын ч бизнесийн үйл ажиллагаанд таатай нөхцөл бий болгож байна.

In recent years, Mongolia has achieved significant progress in its socio-economic development. According to studies, in 2004 the total of budget revenue and foreign development assistance reached 692.8 billion MNT (Mongolian national currency-tugrugs), the total of budget expenditure and net lending was 717.3 billion MNT, and the overall balance showed a budget deficit of 24.5 billion MNT. The current budget revenue totaled to 685.9 billion MNT, whereas the current expenditure was 525.8 billion MNT, thus resulting in a current budget surplus of 160.1 billion MNT.

While the real growth of the GDP has been 1.1% in 2001, 3.7% in 2002 and 5.6% in 2003, respectively, the preliminary estimates have indicated a 10.6% growth for the current year. The steady growth of GDP, the main performance indicator of a national economy, demonstrates improvement at macroeconomic level and provides a favorable environment for business activities of commercial banks and their customers.

ДНБ-ий жилийн өсөлт / Annual growth of GDP




Эх сурвалж: статистик мэдээ / Source: Statistical data

Ажилгүйдлийн түвшин / Unemployment rate




Эх сурвалж: статистик мэдээ / Source: Statistical data

2004 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл (1995 оны зэрэгцүүлэх үнээр) 312.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оныхоос 36.0 тэрбум төгрөг буюу 13 хувиар өслөө.

2000 оноос 2003 оны хооронд ажилгүйдлийн түвшин 5 хувь - 3.5 хувь болтол буурсан хэдий ч 2004 онд ажилгүйдлийн түвшин 3.6 хувь болж өнгөрсөн онтой харьцуулахад 0.1 пунктээр нэмэгдсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2004 оны жилийн эцэст 35.6 мянга болж, өнгөрсөн оныхоос 6.9 хувиар буюу 2.3 мянган хүнээр нэмэгдсэн байна.

In reporting year, the national industrial output reached 312.6 billion MNT (using the price index of 1995), representing a 13.0 percent or 36.0 billion MNT growth in comparison with that of the previous year.

Despite the fall of unemployment rate between 2000 and 2003 from 5.0 percent to 3.5 percent, in 2004 unemployment was 3.6 percent, meaning 0.1 percent growth from that of the previous year. By the end of 2004, the number of unemployed registered at the Employment Authority was 35.6 thousand, demonstrating an increase by 6.9 % or by 2.3 thousand people from the previous year level.

Гадаад худалдааны тэнцэл 2004 онд 158.3 сая ам.долларын алдагдалтай гарч 2003 оноос 26.8 сая ам.доллараар багаслаа. Нийт бараа эргэлт 2003 оноос 31.6 хувиар өссөний дотор экспорт 38.5 хувиар, импорт 26.3 хувиар тус тус өсөв.

2004 оны эцсийн байдлаар нийт мөнгөний хэмжээ 847.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 20.7 хувь буюу 147.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл банкнаас гадуурхи мөнгө 16.9 хувь, төгрөгийн харилцах 9.2 хувь, бараг мөнгө (иргэдийн төгрөгийн болон валютын хадгаламж) 73.9 хувийг тус тус эзэлж байна. 2004 онд бараг мөнгө 135.2 тэрбум төгрөгөөр өссөн нь нийт мөнгөний өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн ба энэ нь банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа сайжирч иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдсэнийг харуулж байна.

2004 оны эцсийн байдлаар, хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон инфляци суурь оноос 27.4 хувь (2000 оны 12 дугаар сар), өмнөх оныхоос 11.0 хувь өсчээ.

**Инфляци, жилийн түвшин / Annual inflation rate**




Эх сурвалж: статистик мэдээ / Source: Statistical data

2004 оны инфляцийн мэдээллийг харвал, 9 дүгээр сараас бусад бүх саруудад инфляци өсөлттэй гарсан байна. Тухбайлбал: Инфляци 2 дугаар сард хамгийн өндөр буюу 2.0 хувь өссөн бол 9 дүгээр сард 0.4 хувиар буурчээ.

2004 онд хэрэглээний сагсны 239 зүйлийн бараа, үйлчилгээний 65.1 хувийнх нь үнэ өсч, 17.2 хувийнх нь үнэ буурч, 21.3 хувийнх нь үнэ тогтвортой байв. Харин 12 дугаар сард 20.9 хувийнх нь үнэ өсч, 8.4 хувийнх нь үнэ буурч, 70.7 хувийнх нь үнэ тогтвортой байсан байна.

The country's foreign trade balance in 2004 produced a trade deficit of 158.3 million USD, declining by 26.8 million USD from 2003. The total trade turnover has increased by 31.6% from 2003, in which the growth of export reached 38.5 % and that of import was 26.3 %.

By the end of 2004, the aggregate money supply was 847.0 billion MNT, indicating an increase of 20.7 % or 147.7 billion MNT from the preceding year. The compositional breakdown of the money supply stock is as follows: currency outside the banking system accounted for 16.9%, MNT current account balances for 9.2 percent and near money (customers' MNT and foreign exchange deposits) for 73.9 percent, respectively. The fact that the percentage share of near money has increased by 135.2 billion MNT in 2004 demonstrates improvement of the activities of banking institutions and the increase of customers' confidence in them.

In late 2004, the inflation rate, calculated on the basis of the consumer price index, has increased by 27.45 % from the base year (December 2000) as well as by 11.0% percent from the preceding year.

According to 2004 inflation rate data, throughout the year except September the inflation rate had been rising. Whereas the inflation rate was the highest in February with 2 percent increase, in September there was a decrease of 0.4%. In 2004, the price level of 65.1 percent of 239 goods and services of consumers' basket increased, while the price of 17.2 percent of them fell, and that of 21.3 percent remained stable. However, in December the price level of 20.9 percent of the consumers' basket has risen, whereas that of 8.4 percent of the basket declined and in case of 70.7 percent it was stable.

# БАНК САНХҮҮГИЙН СИСТЕМ - 2004
## Outlook on banking sector

2004 оны эцсийн байдлаар банк санхүүгийн зах зээлд 17 арилжааны банк, 110 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж үйлчилгээний цар хүрээ өргөжин тэлж зах зээл нэлээд өрсөлдөөнтэй байв. 2004 онд банкны салбарын нийт активын хэмжээ өмнөх оноос 30.3 хувь буюу 249 тэрбум төгрөгөөр өсч дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин 59.5 хувь болсон байна.

As of the end of 2004, there were 17 commercial banks and 110 non-bank financial institutions operating in Mongolia' s banking sector. The range of services they provide was expanded and the market competition was quite tense. In 2004, the total assets of the banking system increased by 30.3 percent (249 billion MNT) from the previous year level, and its percentage share in the GDP reached 59.5%.

**Банкны системийн активын бүтэц / Banking system assets (by structure):**




Банкны салбарын нийт активын 56.8 хувийг цэвэр зээлийн өрийн үлдэгдэл, 13.7 хувийг дотоод гадаадын банкинд байршуулсан хөрөнгө, 11.1 хувийг бэлэн мөнгө болон Монгол банкинд байршуулсан хөрөнгө эзэлж байна. Сүүлийн жилүүдэд зээлийн нийт активт эзлэх хувийн жин тогтмол өсч байсан ба 2004 онд активын өсөлтийн 74.7 хувийг цэвэр зээлийн өсөлт эзэлжээ.

2004 оны 10 дугаар сараас мөрдөх болсон "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам" - д оруулсан өөрчлөлтийн дагуу шинэ аргачлалаар 2004 онд чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 85.0 хувь буюу 18.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 39.1 тэрбум төгрөг болсон нь нийт зээлийн өрийн үлдэгдэлийн 6.0 хувийг эзэлж 2003 оны эцсээс 1.3 нэгжээр өссөн байна.

2004 онд хадгаламж 42.5 хувь буюу 156.2 тэрбум төгрөгөөр (үүнээс иргэдийн хадгаламж 149.2 тэрбум төгрөгөөр), өөрийн хөрөнгө 51.0 хувь буюу 56.6 тэрбум төгрөгөөр, бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 69.7 хувь буюу 45.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт пассивын 57.7 хувийг хадгаламж, 23.3 хувийг харилцах, 12.1 хувийг бусад банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, 4.5 хувь бусад эх үүсвэрээс бүрдэж байна.

Банкны салбарын хэмжээгээр 2004 онд 17.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оноос 25.2 хувь буюу 3.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт орлого 162.2 тэрбум төгрөг байсан нь 2003 оны байдлаас 40.7 хувиар өссөн, нийт зардал 138.7 тэрбум төгрөг байсан нь 46.5 хувиар өссөн байна.

In terms of structure, net credit debt balance accounts for 56.8 percent of the total banking system assets, asset placements with foreign and domestic banks for 13.7 percent, and cash on hand and asset placements with the Bank of Mongolia are making up 11.1 percent. In the recent years, the percentage share of loans in the total assets has been steadily increasing. In 2004, 74.7 percent of the growth of the total assets was due to the increase of net claims on non-banks.

As the calculation, based on a new method introduced according to the "Regulation on Classifying Assets, Founding and Managing Risk Funds", applied from October 2004, shows the net debt balance of non-performing loans increased by 85.0 percent or 18.0 billion MNT reaching the total of 39.1 billion MNT. Thus, it accounts for 6.0 percent of the total outstanding loans, and its percentage share has risen by 1.3 point from the end of 2003.

In 2004, the savings deposits increased by 42.5 percent or 156.2 billion MNT (from which individuals' savings deposits rose by 149.2 billion MNT), capital adequacy by 51.0 percent or by 56.6 billion MNT, inter-bank market liabilities grew by 69.7 percent or 45.0 billion MNT, respectively.

The structure of the banking system liabilities is as follows: 57.7 percent deposits, 23.3 percent current account, 12.1 percent inter-bank market liabilities and 4.5 percent other liabilities.

The banking sector has achieved the profit of 17.3 billion in 2004, representing 25.2 percent or 3.5 billion MNT growth of profits in comparison with the preceding year.

**Банкны системийн пассивын бүтэц / Banking system liabilities (by structure)**




Хүүгийн орлого 134.1 тэрбум, хүүгийн зарлага 65.9 тэрбум төгрөг байлаа.

2003 оны байдлаас татварын өмнөх цэвэр ашиг 14.2 хувь буюу 2.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Активын өгөөжийн үзүүлэлт 2.5 хувь байгаа нь 2003 оноос 0.6 нэгжээр буурчээ. 2003 оны мөн үеийн байдалтай харьцуулахад хүүгийн орлогын өсөлт хүүгийн зардлын өсөлтөөс их байна.

Зээлийн хүүг бодит гарсан орлогоор тооцоолоход 22.3 хувьтай гарсан нь банкны зарласан хүүгийн дунджаас (төгрөгийн) 7.7 нэгжээр бага бөгөөд 2003 онтой харьцуулахад 2.3 нэгжээр буурчээ. Харин бүх төрлийн хадгаламжийн хүүг хадгаламжийн хүүгийн зардлаар тооцоолоход 12.2 хувь байгаа нь зээлийн хүүгээс 10.1 нэгжээр бага, 2003 оны байдлаас 2.3 нэгжээр буурч гарсан байна.

The total revenue was 162.2 billion, after growing by 40.7 percent from 2003, while the total expense was 138.7 billion MNT indicating an increase of 46.5 percent. Furthermore, interest income was 134.1 billion MNT, whereas interest expense was 65.9 billion MNT.

The loan interest rate, calculated on the basis of a real income, was 22.3 percent, which was lower by 7.7 points than the average nominal (MNT) interest rate as well as by 2.3 points than that of its 2003 level. However, the interest rate of all types of deposits, calculated on the basis of the expense of deposits rates, was 12.2 percent, which was lower by 10.1 points than the loan interest rate, and represented a decline of 2.3 points from its level in 2003.




**Улаанбаатар Хотын Банкны II тооцооны төв / Ulaanbaatar City Bank Branch No.2**

# УЛААНБААТАР ХОТЫН БАНКНЫ ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ
## Corporate outline

Улаанбаатар хотын банк нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Улаанбаатар сан /УҮГ/-гийн хөрөнгө оруулалттайгаар нийслэл хотын нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, нийслэлийн болон харъяа дүүргүүдийн иргэд, аж ахуй нэгж, байгууллагад банк санхүүгийн нийтлэг үйлчилгээг үзүүлэх зорилгоор анх 1998 оны 7 дугаар сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм.

Улаанбаатар хотын банк нь байгуулагдсан цагаасаа эхлэн Улаанбаатар хотын нийгэм эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байгаагийн зэрэгцээ Улаанбаатар хот, түүний дүүргүүдэд банкны бүхий л төрлийн үйлчилгээг харилцагчиддаа хүргэхээр ажиллаж байна.

2004 онд нийслэл, түүний харъяа дүүргүүдэд Улаанбаатар хотын банкны 8 салбар, тооцооны төвүүд ажиллаж байгаа ба банкны хэмжээнд 160 гаруй хүн ажиллаж байна.

Улаанбаатар хотын банк нь 2004 онд санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх, ирээдүй рүү чиглэсэн хөрөнгө оруулалтыг хийх, банкны боловсон хүчнийг шинэ залуу, чадварлаг мэргэжилтэнгүүдээр бүрдүүлэх, байгууллагыг бүхий л түвшинд нь бэхжүүлэх зэрэг бодлогыг авч хэрэгжүүллээ.

Улаанбаатар хотын банк нь Монгол улсад анх удаа Монгол даатгал компанитай хамтран Даатгагдсан хадгаламжийн шинэ үйлчилгээг нэвтрүүлсэн. Энэ нь харилцагч үйлчлүүлэгчдийн хүлээж байсан, хүсэл сонирхолд нийцсэн, тэдний банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлсэн үйлчилгээ боллоо.

2004 онд Улаанбаатар хотын банк нь банкны бүртгэлийн шинэ программ нэвтрүүлж, банкны менежментийг сайжруулж, улмаар бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагч байгууллага, иргэдэд улам ойртуулуулах үүднээс хотын төвд 24 цагийн үйлчилгээтэй шинэ салбар нээж ажиллуулж байна.

The Ulaanbaatar City Bank was established with the decision of the Citizens Representatives Assembly of the capital city with investment from the Ulaanbaatar Fund. The Bank started its activities in July 1998 with primary objectives such as contributing to the socio-economic development of the capital city and providing banking services to residents, business enterprises and institutions of the capital city and its districts.

Since its establishment, the Ulaanbaatar City Bank has been making substantial contributions to the economic development of Ulaanbaatar city, and working on delivering all ranges of banking services to its customers.

As of 2004, the Bank is operating with eight branches in the city and its districts, employing more than 160 people.

In 2004, the Bank has taken a number of steps to consolidate its market position, invest into its future, build a team of young, competent banking experts and enhance the Bank's capacity building at all levels.

In collaboration with the "Mongol Daatgal" Company, the Ulaanbaatar City Bank has pioneered in introduction of a new service of Insured Savings Deposits in Mongolia. This type of innovative service meets the expectations and interests of our customers, and has boosted customer's confidence in banking institutions.

In 2004, Ulaanbaatar City Bank adopted a modern accounting software, improved its management, and to reduce the gap to the customers we have also opened a 24 hours settlement center.

# БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
## Organization



# ШАГНАЛ ӨРГӨМЖЛӨЛ - 2004
## Awards and Prizes - 2004

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр `` Нийслэлийн 2004 оны шилдэг аж ахуйн нэгж``
- Монгол Улсын Засгийн Газар, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас 2003 онд Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан гэж "Монгол Улсын Шилдэг банк"
- TV9 телевизээс 2004 онд техник, технологийн шинэчлэл хийж, менежментийн зөв зохистой бодлого нэвтрүүлж, олон түмний талархал хүлээсэн үйлчилгээ нэвтрүүлсэн гэж "Оны шилдэг аж ахуйн нэгж"
- Гүйцэтгэх захирал Д.Бадраа МҮХАҮТ-аас зохион байгуулсан ``ENTREPRENEUR-2004`` шалгаруулалтаас "Банк санхүүгийн системийн шилдэг менежер"
- Гүйцэтгэх захирал Д.Бадраа Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх, нийслэл хотынхоо хөгжил цэцэглэлтийн төлөө өөрийн авъяас билэг, мэдлэг чадвар, ажил мэргэжлийн амжилтаараа банк санхүүгийн салбарт тэргүүлж "2004 оны Нийслэлийн шилдэг залуу" хүндэт өргөмжлөлөөр тус тус шагнагдсан.

- With the decision of the Citizens Representatives Assembly of the Capital city, the bank was awarded with a title of " The best Business Enterprise of the Capital city in 2004".
- With a joint decision of the Government of Mongolia and the Mongolian National Chamber of Commerce and Industry in 2003 the bank was granted with the title of the "The Best Bank of Mongolia", in recognition of its substantial contribution to Mongolia's economic development.
- Recognizing the significance of the bank's technological and technical renovation, introduction of the most appropriate management policy and provision of quality services, the TV9 Television named the bank as "The Best Business Enterprise of the Year".
- The bank's Executive Director, Mr. D. Badraa has won the award of "Distinguished Manager in Banking and Finance" in the "ENTREPRENEUR" contest organized by the Mongolian National Chamber of Commerce and Industry.
- For his contribution to the realization of the Action Plan of the City Mayor, advancing the socio-economic development goals and devoting his skills, knowledge and achievements for the prosperity of the capital city, the bank's Executive Director, Mr. D. Badraa, was conferred the title "The Best Young Fellow of the Capital City".



# САНХҮҮГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
## Main financial indicators

### ХӨРӨНГӨ

2004 онд банкны нийт хөрөнгө 29.8 тэрбумд хүрч 2003 оноос 115 хувь буюу 15.9 тэрбум төгрөгөөр өслөө.
Үүнийг графикаар харуулбал:

### ASSETS

In 2004, the bank's total asset reached 29.8 billion MNT, increasing by 115 percent and 15.9 billion MNT from 2003, as illustrated on the following graphics:

Хөрөнгийн өсөлт (сая төг) / Growth of assets (in million MNT)




Тайлант хугацааны эцэст нийт активын 5.8 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг бэлэн мөнгө, 36.4 хувь буюу 10.8 тэрбум төгрөгийг бусад банкинд байршуулсан хөрөнгө, 2.4 хувь буюу 0.7 тэрбум төгрөгийг үнэт цаас, 40.4 хувь буюу 12 тэрбум төгрөгийг зээл ба авлага, 5.7 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг бусад актив, 9.3 хувь буюу 2.7 тэрбум төгрөгийг үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

By the end of the reporting period, the composition of the total assets was as follows: 5.8 percent or 1.7 billion MNT cash on hand, 36.4 percent or 10.8 billion MNT asset placements with other banks, 2.4 percent or 0.7 billion MNT securities, 40.4 percent or 12 billion MNT loans and claims, 5.7 percent or 1.6 billion MNT other assets, and 9.3 percent or 2.7 billion MNT of them were property, plant and equipment, respectively.

Хөрөнгийн бүтэц / Assets (by structure)



# САНХҮҮГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (үргэлжлэл)
## Main financial indicators (contd.)

Зээлийн бүтцийг салбараар харуулбал 36.4 хувийг худалдаа, 21.2 хувийг барилга, 16.5 хувийг боловсруулах үйлдвэр, 9.6 хувийг дулаан цахилгааны үйлдвэрлэл, 16.3 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

